



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.1, 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол улсаас Оросын холбооны Эрхүү хотод суугаа Ерөнхий консулын газар, Улаан-Үд хотод суугаа Ерөнхий консулын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон нийт 106,788.00 (нэг зуун зургаан мянга долоон зуун наян найман) ам долларын балансын үнэ бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Даваасүрэн, Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Эрхүү хотод суугаа Ерөнхий консул Л.Амарсанаа, Улаан-Үд хотод суугаа суугаа Ерөнхий консул Д.Чадраабал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж устгах, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулагтын газрын 2018  
оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 12:00 дугаар  
тогтоолын хавсралт

**Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, актаж, худалдах**

| Д/д  | Автомашины марк, улсын дугаар,<br>зориулалт, хөдөлгүүр, арлын<br>дугаар  | Үйлдвэрлэсэн<br>ОН | Нийт<br>гүйлгт<br>/км/ | Балансын үнэ<br>төгрөг (ам.доллар)  | Хуримтлагдсан<br>элэгдэл<br>(ам.доллар)                                       | Үлдэх өртөг<br>(ам.доллар) | Худалдах<br>доод үнэ<br>(ам.доллар)            |
|--|--|--------------------|------------------------|---|---|----------------------------|--|
| <b>1. ОХУ-ЫН ЭРХҮҮХ ХОТОД СУУГАА МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР</b>   |  |                    |                        |   |   |                            |  |
| 1  | Төёото Хайс маркийн, 089D00738<br>улсын дугаартай, автобус, арлын<br>дугаар JTFSX22P106034284                    | 1999               | 102350                 | 37,153.00   | 37,153.00   |                            | - 500.00                                       |
| 2  | Ниссан патрол маркийн, 089D00738<br>улсын дугаартай, автомашин, арлын<br>дугаар JN1TFSY61Z05555251<br><b>ДҮН</b> | 2002               | 95000                  | 40,135.0  | 40,135.0  |                            | - 1,500.00                                     |
| <b>2. ОХУ-ЫН УЛААН-ҮД ХОТОД СУУГАА МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР</b> |  |                    |                        |   |   |                            |  |
| 1  | Төёото Хайс маркийн, 089CD203<br>улсын дугаартай, автобус, арлын<br>дугаар JTJX02P200019321<br><b>ДҮН</b>        | 2008               | 112110                 | 29,500.00   | 29,500.00   |                            | - 1,000.00                                     |
| <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>  |  |                    |                        |   |   |                            |  |
|  |  |                    |                        | 29,500.00   | 29,500.00   | 0.00                       | <b>1,000.00</b>                                |
|  |  |                    |                        | 106,788.00  | 106,788.00  | 0.00                       | <b>3,000.00</b>                                |
|  |  |                    |                        | 106,788.00 (нэг зуун<br>зургаан мянга<br>долоон зуун наян<br>найман амдоллар) | 106,788.00 (нэг зуун<br>зургаан мянга<br>долоон зуун наян<br>найман амдоллар) |                            | <b>2,000.00 (хоёр<br/>мянга ам<br/>доллар)</b> |